


# Вакцинжуулалт

*(Гарын авлага-ДҮҮРЭГ)*

***“Системийн чанар, нэвтрүүлэлтийн баг”***

**УЛААНБААТАР ХОТ**

**2021 ОН**

# АГУУЛГА


**1. Системд нэвтрэх болон Төлөвлөлт** ........ 3
1.1 СИСТЕМД НЭВТРЭХ: ........ 3
1.2 ХУВААРИЛАЛТ (ДҮҮРЭГ): ........ 3
1.2.1 Хуваарилах захиалга ........ 3
1.2.2 Хуваарилагдсан захиалга ........ 4
1.3 ЗАХИАЛГА ХИЙХ ........ 4
1.3 ЗАХИАЛГЫГ ХУВААРИЛАХ ........ 5
**2. ХҮЛЭЭН АВАХ (Дүүрэг)** ........ 6
2.1 Хүлээн авах захиалга ........ 6
2.2 Хүлээн авах захиалга ........ 7
**3. Хорогдол (ӨЭМТ)** ........ 7
**4. Тайлан** ........ 9
4.1. Бараа материалын тайлан ........ 9
4.2. Бараа материалын үлдэгдлийн тайлан цувралаар ........ 9

# 1. Системд нэвтрэх болон Төлөвлөлт

## 1.1 СИСТЕМД НЭВТРЭХ:

Дүүргийн мэргэжилтэн буюу систем хэрэглэгч нь https://www.health.gov.mn/ -д хандалт хийж орсны дараа Дүүрэг агуулахын менежер буюу өөрийн эрх дээр дарж системийн үндсэн цонх руу орно.




***Хуваарилалт (Дүүрэг):***

Өрхийн эмнэлгээс ирсэн төлөвлөгөөт захиалгыг ХӨСҮТ рүү илгээх болон ХӨСҮТ -ээс төлөвлөгөөний дагуу ирсэн вакциныг Өрх рүү дамжуулах хуваарилалтыг бүртгэнэ.

***Хүлээн авах (Дүүрэг):***

ХӨСҮТ -ээс ирсэн вакциныг дүүрэг дээрээ хүлээн авч буй бүртгэлийг хийнэ.

***Хорогдол (ӨЭМТ):***

Вакцинд хаягдал, гологдол гарсан бол түүнийг бүртгэх хэсэг

## 1.2 ХУВААРИЛАЛТ (ДҮҮРЭГ):

### 1.2.1 Хуваарилах захиалга




| № | Захиалгын дугаар | Захиалга хийсэн | Захиалга хийсэн огноо | Тайлбар | Нийт | Төлөв | Үйлдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2021021810 | Энх-агшин эзмт | 2021-02-18 | 12 | 600 | ХӨСҮТ захиалга илгээсэн | |
| 2 | 2021021811 | Энх-агшин эзмт | 2021-02-18 | 10 | 100 | Шинэ | |
| 3 | 2021021808 | Энх-агшин эзмт | 2021-02-18 | 12 | 2,000 | ХӨСҮТ захиалга илгээсэн | |
| 4 | 2021021809 | Энх-агшин эзмт | 2021-02-18 | 12 | 1,500 | ХӨСҮТ захиалга илгээсэн | |
| 5 | 2021021807 | Энх-агшин эзмт | 2021-02-18 | Тайлбар orh Ikhagva | 30 | ХӨСҮТ захиалга илгээсэн | |

- Сэргээх

Захиалга хийх, Захиалгыг хуваарилах үед дэлгэцийн цонхыг шинэчлэлт /update/ хийж үүссэн мэдээллийг сүүлийн байдлаар харах боломжтой товч юм.

- Захиалга хийх

Өрхийн эмнэлгээс ирсэн төлөвлөгөөт захиалгыг ХӨСҮТ рүү илгээх хэсэг.

- Захиалгыг хуваарилах

Төлөвлөгөөний дагуу ХӨСҮТ-ээс ирсэн вакциныг захиалгын дагуу өрхийн эмнэлэг рүү хуваарилах хэсэг.

### 1.2.2 Хуваарилагдсан захиалга

Дүүрэг өрхийн эмнэлгүүдээс төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу захиалга хийх болон дүүргээс өрхийн эмнэлгүүд рүү вакциныг нийлүүлсэн мэдээллийг Хуваарилагдсан захиалга хэсгээс харах боломжтой.




## 1.3 ЗАХИАЛГА ХИЙХ

Тухайн өрхийн зорилтот бүлэг хүмүүст шаардлагатай вакцины төлөвлөгөөг сонгож, **Захиалга хийх** товчийг дарна. Өрхийн эмнэлгээс илгээсэн захиалга нь Шинэ төлөвтэй байна.




Гарч ирсэн талбарт тайлбар оруулж, **Захиалга хийх** товч дарна.



**ҮР ДҮН:**

Захиалга хийгдсэний дараа **Хуваарилалт (Дүүрэг)** хэсэгт **ХӨСҮТ захиалга хийгдсэн** төлөвийг харуулна.




## 1.3 ЗАХИАЛГЫГ ХУВААРИЛАХ

ХӨСҮТ-ээс ирсэн захиалгыг хүлээн авсны дараа өрхийн эмнэлэг рүү захиалгыг хуваарилах бүртгэл хийнэ. Үүний тулд Захиалгыг хуваарилах товчийг дарж, гарч ирсэн талбарын мэдээллийг хянасны дараа **Баталгаажуулах** товчийг дарна.



**ҮР ДҮН:**

Ирсэн вакцин нь Өрхийн эмнэлэг рүү хуваарилагдана

# 2. ХҮЛЭЭН АВАХ (Дүүрэг)

## 2.1 Хүлээн авах захиалга

Тухайн үүсгэсэн төлөвлөгөөний дагуу ирсэн вакциныг Дүүргийн эмнэлэг дээрээ хүлээж авсан бүртгэл хийнэ. Үүний тулд **Захиалга хүлээн авах** товчийг дарж, холбогдох тайлбар мэдээллийг бүрэн бөглөсний дараа **Хүлээн авах** товчийг дарна.




**ҮР ДҮН:**

Ирсэн вакциныг хүлээн авсан бүртгэл хийсний дараа өрхийн эмнэлэгт хуваарилах боломжтой болно.

## 2.2 Хүлээн авах захиалга

Төлөвлөгөөний дагуу ирсэн вакцины хүлээн авсан мэдээллийг харах бол Хүлээн авсан захиалга товчийг дарна.




# 3. Хорогдол (ӨЭМТ)

Тухайн вакциныг тээвэрлэх явцад эсвэл ямар нэгэн шалтгаанаар ашиглаж чадахааргүй нөхцөл байдал үүссэн бол тухайн вакциныг ашиглах боломжгүй гэж үзэн Хорогдлыг бүртгэнэ. Хорогдол(ӨЭМТ) цэсийг дарж, тухайн талбарт байрших +НЭМЭХ товчийг дарснаар хорогдлыг бүртгэх боломжтой болно.




**Дараах шалтгааны төрлүүд байж болно.** Үүнд:

- Мэргэжилтний үйл ажиллагаанаас
- Тээвэрлэлтийн явцад хагарсан
- Тээвэрлэлтийн үед хэмийн нөлөөнд өртсөн

- Буруу хадгалсан
- Тарих үеийн техник ажиллагаанаас
- Вакцин задалснаас хойш хүн ирээгүй
- Тарих хэмжээндээ хүрээгүй
- Хугацаа дууссан гэх мэт сонголтууд

**Бүтээгдэхүүний төрөл**

- Вакцин
- Тариур
- Вакцин найруулах ус

**Бүтээгдэхүүн**

- Ковид-19
- Томуу
- А гепатит гэх мэт

**Худалдааны нэр**

Хайлт хэсэгт дарахад тухайн бүтээгдэхүүний үлдэгдэл хэмжээ болон дуусах хугацаа, үйлдвэрлэгч байгууллагын мэдээлэл бүхий вакцинууд гарах бөгөөд тухайн хорогдол үүссэн вакцины сонгоно.

**Цувралын №** -Сонголтоор

**Дуусах хугацаа** -Сонголтоор

**Тун**

Тунгийн хэмжээг оруулна. Оруулах тунгийн хэмжээ нь тухайн вакцины үлдэгдлээс их байж болохгүй.

**Тайлбар**

Тухайн вакцинд хорогдол үүссэн болон дэлгэрэнгүй тайлбар мэдээллийг оруулан хадгална.

**Бүртгэсэн**

Тухайн вакцины хорогдлыг бүртгэсэн эмч сонгогдсон байдлаар гарч ирнэ.

Бүх талбарын мэдээллийг бүрэн бөглөсний дараа **ХАДГАЛАХ** товчийг дарна.

# 4. Тайлан

Эмнэлэг тус бүрээр болон бүх эмнэлгүүдээр вакцины тайланг сонгосон хугацаагаар хураангуй болон дэлгэрэнгүй байдлаар харах боломжтой. Мөн тухайн тайланг хөрвүүлэлт хийх, хуулж авах боломжтой.

## 4.1. Бараа материалын тайлан

Тайлан үндсэн цэсийн Бараа материалын тайлан талбарыг сонгож, хугацааг оруулсан дараа хайх товч дарна. Тухайн тайлан нь орлого, зарлагын хэмжээ болон тухайн вакцины дуусах хугацаа, үйлдвэрлэгчийн мэдээллийг харуулна.




| № | Баримтын № | Баримтын огноо | Баримтын төрөл | Вакцин бүлэг | Вакцин | Агуулах | Орлого тоо хэмжээ | Зарлага тоо хэмжээ | Цувралын дугаар | Дуусах хугацаа | Үйлдвэрлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2021022201 | 2021-02-22 | Хөсүт орлого | Ковид-19 | Pfizer | ХӨСҮТ | 1,000 | | 1 | 2022-02-28 | BioNTech |
| 2 | 2021022202 | 2021-02-22 | Хөсүт орлого | Ковид-19 | SARS-CoV-2 | ХӨСҮТ | 20,000 | | 136465321 | 2021-02-28 | Asia farm Co.L |
| 3 | 2021022203 | 2021-02-22 | Агуулах шилж... | Ковид-19 | SARS-CoV-2 | ХӨСҮТ-5л агу... | 500 | | 136465321 | 2021-02-28 | Asia farm Co.L |
| 4 | 2021022203 | 2021-02-22 | Агуулах шилж... | Ковид-19 | SARS-CoV-2 | ХӨСҮТ | | 500 | 136465321 | 2021-02-28 | Asia farm Co.L |
| 5 | 2021022204 | 2021-02-22 | Хөсүт зарлага | Ковид-19 | Pfizer | ХӨСҮТ | | 555 | 1 | 2022-02-28 | BioNTech |
| 6 | 2021022202 | 2021-02-22 | Дүүрэг орлого | Ковид-19 | Pfizer | | 555 | | 1 | 2022-02-28 | BioNTech |
| 7 | 2021022202 | 2021-02-22 | Дүүрэг зарлага | Ковид-19 | Pfizer | | | 555 | 1 | 2022-02-28 | BioNTech |
| 8 | 2021022201 | 2021-02-22 | | Ковид-19 | Pfizer | | 555 | | 1 | 2022-02-28 | BioNTech |
| 9 | 2021022205 | 2021-02-22 | Агуулах шилж... | Ковид-19 | SARS-CoV-2 | ХӨСҮТ-5л агу... | 2,000 | | 136465321 | 2021-02-28 | Asia farm Co.L |
| 10 | 2021022205 | 2021-02-22 | Агуулах шилж... | Ковид-19 | SARS-CoV-2 | ХӨСҮТ | | 2,000 | 136465321 | 2021-02-28 | Asia farm Co.L |
| 11 | 2021022206 | 2021-02-22 | Хөсүт зарлага | Ковид-19 | SARS-CoV-2 | ХӨСҮТ | | 9,000 | 136465321 | 2021-02-28 | Asia farm Co.L |
| | | | | | | | 224,070 | 51,739 | | | |

## 4.2. Бараа материалын үлдэгдлийн тайлан цувралаар

Тайлан үндсэн цэсийн Бараа материалын үлдэгдлийн тайлан цувралаар талбарыг сонгож, хугацааг оруулсан дараа хайх товч дарна. Тухайн тайлан нь орлого, зарлагын хэмжээ болон тухайн вакцины дуусах хугацаа, үйлдвэрлэгчийн мэдээлэл, эхний үлдэгдэл, тарьсан тоон хэмжээг харуулна.




| № | Бүтээгдэхүү төрөл | Вакцин бүлэг | Вакцин | Агуулах | Цуврал | Дуусах огноо | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Вакцин тарьсан | Эцсийн үлдэгдэл | Үйлдвэрлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Вакцин | Ковид-19 | Pfizer | | 1 | 2022-02-28 | | 444 | 222 | | 222 | BioNTech |

Тухайн тайланг хөрвүүлэлт хийх бол Mouse2 товчийг дарна.

